

# ХААН СОЁМБО АУДИТ ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/168/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2023 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88012671 Цахим хаяг: [ichinkhorloog@audit.gov.mn](mailto:ichinkhorloog@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Гүйцэтгэсэн аудитын менежер: Л.Магсаржалам  
Утас: 88114867 Цахим хаяг:  
[khaan.soyombo.audit@gmail.com](mailto:khaan.soyombo.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	16
3.5.3 Нэмэлт төсөв .....	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
5.1 Төлбөрийн акт .....	18
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

№ 023.02.24 № 01/182  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Ч.МӨНХБОЛОР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлж байна. Тус байгууллага нь гүйцэтгэлээр санхүүжилт авсан боловч мөнгөн хөрөнгийн дансанд 138,072.3 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эм, багаж тоног төхөөрөмжийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 27,378.5 мянган төгрөгийн эм, 23,852.2 мянган төгрөгийн багаж тоног төхөөрөмж нийт 51,230.7 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Тосонцэнгэл сумын эрүүл мэндийн төв нь 2022 онд 5 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас 93.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг

буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>276,061,348.28</b>	<b>312,680,216.96</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	41,551	138,072,334.64
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	41,551.00	138,072,334.64
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	41,551.00	138,072,334.64
31211	Төрийн сангийн харилцах	41,551.00	138,072,334.64
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	106,547,600.00	7,700,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	106,547,600.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	7,700,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	7,700,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	169,472,197.28	166,907,882.32
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	128,478,001.28	122,589,910.02
35130	Эм боох материал	128,478,001.28	122,589,910.02
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	40,994,196.00	44,317,972.30
35410	Бичиг хэргийн материал	941,589.00	1,446,100.00
35420	Аж ахуйн материал	33,030,185.00	33,429,708.00
35440	Түлш, шатах тослох материал	2,771,830.00	3,483,000.00
35460	Хүнсний материал	3,007,092.00	4,935,664.30
35470	Бусад хангамжийн материал	1,243,500.00	1,023,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>294,145,320.45</b>	<b>316,567,841.76</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	294,145,320.45	316,567,841.76
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	281,516,987.09	304,130,508.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	80,657,287.10	80,657,287.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-32,496,631.92	-43,328,842.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	52,300,000.00	61,484,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-13,085,625.23	-18,317,091.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	153,983,243.93	214,006,139.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-27,848,816.30	-54,191,985.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,366,271.00	51,528,793.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,227,080.28	-13,196,845.09
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,262,894.51	33,262,894.51
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,394,555.72	-7,773,840.96
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	12,628,333.36	12,437,333.44
39301	Програм хангамж	955,000.00	955,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-36,666.64	-227,666.56
39303	Бусад биет бус хөрөнгө	11,710,000.00	11,710,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>570,206,668.73</b>	<b>629,248,058.72</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>23,902,138.00</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	23,902,138.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	23,902,138.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	23,902,138.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>546,304,530.73</b>	<b>629,248,058.72</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	546,304,530.73	629,248,058.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	243,350,497.80	243,350,497.80

Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51101	Өмч: - төрийн	243,350,497.80	243,350,497.80
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>198,405,442.83</b>	<b>281,348,970.82</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	198,405,442.83	198,405,442.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	82,943,527.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	104,548,590.10	104,548,590.10
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>570,206,668.73</b>	<b>629,248,058.72</b>

2.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А  
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,253,654,008.10</b>	<b>810,719,256.28</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>384,579,058.10</b>	<b>115,131,736.28</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	384,579,058.10	115,131,736.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	384,579,058.10	115,131,736.28
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	384,579,058.10	115,131,736.28
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>869,074,950.00</b>	<b>695,587,520.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	402,266,000.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	402,266,000.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	392,978,950.00	1,033,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	446,200.00	360,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,844,250.00	673,000.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	39,648,000.00	68,769,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,648,000.00	68,769,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	34,182,000.00	625,785,520.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	34,182,000.00	625,785,520.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>998,152,181.28</b>	<b>727,775,728.29</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>998,152,181.28</b>	<b>727,775,728.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	964,652,181.28	726,318,086.29
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	384,687,567.00	353,237,577.32
210101	Үндсэн цалин	201,935,967.00	228,034,219.38
210102	Нэмэгдэл	118,917,900.00	86,510,093.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,300,000.00	5,096,000.00
210104	Урамшуулал	48,304,000.00	22,697,338.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,229,700.00	10,899,926.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	49,658,432.00	44,781,972.04
210201	Тэтгэврийн даатгал	34,331,348.00	30,583,291.18
210202	Тэтгэмжийн даатгал	3,842,833.00	3,602,365.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,074,865.00	2,858,049.77
210204	Ажилгүйдлийн даатгал	761,686.00	696,736.73
210205	Эрүүл мэндийн даатгал	7,647,700.00	7,041,528.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	60,050,138.00	39,529,082.00
210301	Гэрэл, цахилгаан	3,251,738.00	3,342,620.00
210302	Түлш, халаалт	55,598,400.00	35,186,462.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	34,999,499.17	47,140,294.16
210401	Бичиг хэрэг	4,273,330.00	4,380,804.00

Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	8,932,934.00	13,499,722.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,841,770.00	2,910,253.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	3,360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,651,465.17	22,989,515.16
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>378,291,959.24</b>	<b>154,525,078.08</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	364,463,415.04	132,356,108.38
210502	Хоол, хүнс	13,828,544.20	15,668,969.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	6,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,500,000.00</b>	<b>7,120,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	930,000.00
210604	Урсгал засвар	3,500,000.00	6,190,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>654,000.00</b>	<b>1,483,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	654,000.00	1,483,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,609,647.00</b>	<b>10,081,136.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	320,600.00	7,343,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	1,710,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	125,000.00	125,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,536.00	85,536.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	117,100.00	117,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,056,411.00	644,550.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>49,200,938.87</b>	<b>68,419,046.69</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,510,350.00	9,374,850.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,690,588.87	59,044,196.69
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33,500,000.00</b>	<b>1,457,642.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>33,500,000.00</b>	<b>00.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	33,500,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>1,457,642.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,457,642.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>255,501,826.82</u></b>	<b><u>82,943,527.99</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>22,166,152.67</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	22,166,152.67	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-22,166,152.67</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>233,335,674.15</u></b>	<b><u>82,943,527.99</u></b>

2.3 Мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>762,527,350.00</u></b>	<b><u>802,135,120.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>106,547,600.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	106,547,600.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	106,547,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	106,547,600.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>762,527,350.00</b>	<b>695,587,520.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	402,266,000.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	286,431,350.00	1,033,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	446,200.00	360,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,844,250.00	673,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	420,000.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	39,648,000.00	68,769,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,648,000.00	68,769,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	34,182,000.00	625,785,520.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	34,182,000.00	625,785,520.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	00.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>747,080,799.00</u></b>	<b><u>631,146,336.36</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>747,080,799.00</b>	<b>631,146,336.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>713,580,799.00</b>	<b>629,688,694.36</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	384,687,567.00	353,237,577.32
210101	Үндсэн цалин	201,935,967.00	228,034,219.38
210102	Нэмэгдэл	118,917,900.00	86,510,093.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,300,000.00	5,096,000.00
210104	Урамшуулал	48,304,000.00	22,697,338.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,229,700.00	10,899,926.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	49,658,432.00	44,781,972.04
210201	Тэтгэврийн даатгал	34,331,348.00	30,583,291.18
210202	Тэтгэмжийн даатгал	3,842,833.00	3,602,365.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,074,865.00	2,858,049.77
210204	Ажилгүйдлийн даатгал	761,686.00	696,736.73
210205	Эрүүл мэндийн даатгал	7,647,700.00	7,041,528.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,148,000.00	63,431,220.00
210301	Гэрэл, цахилгаан	3,251,738.00	3,342,620.00
210302	Түлш, халаалт	31,696,262.00	59,088,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	31,444,014.00	41,822,580.00
210401	Бичиг хэрэг	4,309,430.00	4,746,675.00
210402	Тээвэр, шатахуун	11,072,314.00	14,210,892.00

Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,881,770.00	2,910,253.00
210404	Ном, хэвлэл	280,500.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	3,360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,600,000.00	16,594,760.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>193,764,500.00</b>	<b>96,476,819.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	177,519,150.00	72,794,492.00
210502	Хоол, хүнс	14,245,350.00	17,182,327.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	6,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,500,000.00</b>	<b>9,120,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	2,930,000.00
210604	Урсгал засвар	3,500,000.00	6,190,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>654,000.00</b>	<b>1,483,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	654,000.00	1,483,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,993,936.00</b>	<b>10,219,776.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	320,600.00	7,343,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	1,710,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	125,000.00	125,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,536.00	85,536.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	117,100.00	117,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,440,700.00	783,190.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,730,350.00</b>	<b>9,114,850.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,730,350.00	9,114,850.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33,500,000.00</b>	<b>1,457,642.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>33,500,000.00</b>	<b>00.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	33,500,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>1,457,642.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,457,642.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>15,446,551.00</u></b>	<b><u>170,988,783.64</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>15,405,000.00</b>	<b>32,958,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,405,000.00</b>	<b>32,958,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>15,405,000.00</b>	<b>32,958,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,405,000.00	32,958,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-15,405,000.00</u></b>	<b><u>-32,958,000.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>41,551.00</b>	<b>138,030,783.64</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>41,551.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>41,551.00</b>	<b>138,072,334.64</b>

## 2.4 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	243,350,497.80	104,548,590.10	-131,010,285.85	216,888,802.05
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	243,350,497.80	104,548,590.10	-131,010,285.85	216,888,802.05
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	96,080,054.53	96,080,054.53
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	243,350,497.80	104,548,590.10	198,405,442.83	546,304,530.73
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	243,350,497.80	104,548,590.10	198,405,442.83	546,304,530.73
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	243,350,497.80	104,548,590.10	198,405,442.83	546,304,530.73
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	82,943,527.99	82,943,527.99
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	243,350,497.80	104,548,590.10	281,348,970.82	629,248,058.72

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	716,559,900.00	664,104,336.36	52,455,563.64	92.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	716,559,900.00	664,104,336.36	52,455,563.64	92.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	647,790,900.00	595,335,336.36	52,455,563.64	91.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	353,648,600.00	350,717,282.32	2,931,317.68	99.2
210101	Үндсэн цалин	194,977,900.00	228,034,219.38	-33,056,319.38	117.0
210102	Нэмэгдэл	115,779,100.00	86,510,093.94	29,269,006.06	74.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,825,000.00	5,096,000.00	1,729,000.00	74.7
210104	Урамшуулал	26,067,000.00	22,697,338.00	3,369,662.00	87.1
210105	Гэрээт ажлын хөлс	9,999,600.00	10,899,926.00	-900,326.00	109.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,251,100.00	44,422,129.04	828,970.96	98.2
210201	Тэтгэврийн даатгал	31,413,700.00	30,583,291.18	830,408.82	97.4
210202	Тэтгэмжийн даатгал	3,460,400.00	3,602,236.74	-141,836.74	104.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,766,100.00	2,858,049.77	-91,949.77	103.3
210204	Ажилгүйдлийн даатгал	689,300.00	696,736.73	-7,436.73	101.1
210205	Эрүүл мэндийн даатгал	6,921,600.00	7,041,528.62	-119,928.62	101.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,888,600.00	63,431,220.00	1,457,380.00	102.3
210301	Гэрэл, цахилгаан	4,800,000.00	3,342,620.00	1,457,380.00	69.6

Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	59,088,600.00	59,088,600.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210304	Байрны түрээс	0	0	0.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>46,543,800.00</b>	<b>41,822,580.00</b>	<b>4,721,220.00</b>	<b>89.9</b>
210401	Бичиг хэрэг	5,125,000.00	4,746,675.00	378,325.00	92.6
210402	Тээвэр, шатахуун	16,101,200.00	14,210,892.00	1,890,308.00	88.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,278,900.00	2,910,253.00	368,647.00	88.8
210404	Ном, хэвлэл	137,500.00	0	137,500.00	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,026,100.00	3,360,000.00	1,666,100.00	66.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,875,100.00	16,594,760.00	280,340.00	98.3
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>129,738,500.00</b>	<b>96,476,819.00</b>	<b>33,261,681.00</b>	<b>74.4</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	105,105,600.00	72,794,492.00	32,311,108.00	69.3
210502	Хоол, хүнс	18,132,900.00	17,182,327.00	950,573.00	94.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,500,000.00	6,500,000.00	0.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>51,677,200.00</b>	<b>41,078,000.00</b>	<b>10,599,200.00</b>	<b>79.5</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	33,352,200.00	32,958,000.00	394,200.00	98.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,135,000.00	2,930,000.00	8,205,000.00	26.3
210604	Урсгал засвар	8,190,000.00	6,190,000.00	2,000,000.00	75.6
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,671,500.00</b>	<b>1,483,900.00</b>	<b>1,187,600.00</b>	<b>55.5</b>
210702	Дотоод албан томилолт	2,671,500.00	1,483,900.00	1,187,600.00	55.5
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,015,600.00</b>	<b>10,219,776.00</b>	<b>1,795,824.00</b>	<b>85.1</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,500,000.00	7,343,950.00	1,156,050.00	86.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,710,000.00	1,710,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	230,000.00	125,000.00	105,000.00	54.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	85,536.00	64,464.00	57.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	120,000.00	117,100.00	2,900.00	97.6
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,250,600.00	783,190.00	467,410.00	62.6
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9125000</b>	<b>9,114,850.00</b>	<b>10,150.00</b>	<b>99.9</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,125,000.00	9,114,850.00	10,150.00	99.9
	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,457,642.00	-1,457,642.00	0.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>716,559,900.00</b>	<b>802,135,120.00</b>	<b>-85,575,220.00</b>	<b>111.9</b>
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>524,570,300.00</b>	<b>610,145,520.00</b>	<b>-85,575,220.00</b>	<b>116.3</b>

134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	524,570,300.00	610,145,520.00	-85,575,220.00	116.3
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	122,187,600.00	122,187,600.00		100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	122,187,600.00	122,187,600.00	0.00	100.0
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	68,769,000.00	68,769,000.00	0.00	100.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	0	41,551.00	-41,551.00	0.0
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	0	138,072,334.64	-138,072,334.64	0.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	24	24	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	6	6	0.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

#### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд оновчтой бодлого, мэдлэгтэй чадварлаг ёс зүйтэй хамт олныг бүрдүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлэх орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах замаар хүн амын дундаж наслалтыг уртасгана.

Тосонцэнгэл сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэдийг эрт илрүүлэгт хамруулах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх
- Үйлчлүүлэгчдэд болон эмч ажилчдад ээлтэй орчин бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлж тасралтгүй байдлыг хангах

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

#### *Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан<sup>1</sup> 01,02 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан<sup>2</sup> тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох

<sup>1</sup> "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай"

<sup>2</sup> "Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай"

нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ гэсэн арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.

**Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:**

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 05 сарын 25-ны өдрийн А/36 тоот тушаалаар дотоод хяналтын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 15 заалт бүхий 9 ажлын төлөвлөгөө гаргаж хяналт шалгалтыг зохион байгуулж дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. Тухайлбал: Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төв нь Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар 2019 онд баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 59,041.4 мянган төгрөгөөр бууу 11.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	41,551.0	138,072.3	96,521.3
Авлага	106,547.6	0	-106,547.6
Бараа материал	169,472.2	166,907.9	-2,564.3
Үндсэн хөрөнгө	294,145.3	316,567.8	22,422.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>570,206.6</b>	<b>629,248.0</b>	<b>59,041.4</b>
Өр төлбөр	23,902.1	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	546,304.5	546,304.5	0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>570,206.6</b>	<b>629,248.0</b>	<b>59,041.4</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө дансуудад өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 96,521.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 2,564.3 мянган төгрөгөөр буурсан корона вирусны үеийн вакцины үлдэгдэл тайлант онд зарцуулсантай холбоотой байна.
3. Үндсэн хөрөнгө данс 22,422.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 81,466.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 25,258.0 мянган төгрөг, 56,208.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авсан байна.

Өмнөх оны Эрүүл мэндийн даатгалаас авах 106,547.6 мянган төгрөгийн авлага барагдуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгал 625,785.5 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс санхүүжилт 68,769.0

мянган төгрөгийн санхүүжилт, ЭМГ-аас 1,033.0 мянган төгрөгийн сургалтын зардал орсон байна. Нийт зарлагыг 694,400.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Орон нутгийн санхүүжилтийг тайлант онд 5,511.0 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр Эрүүл мэндийн даатгалаас гүйцэтгэлээр 625,785.5 мянган төгрөг, Орон нутгийн урсгал санхүүжилт 68,769.0 мянган төгрөгийг тус тус үйл ажиллагааны орлого бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалаас 625,785.5 мянган төгрөг, Орон нутгийн орлогоос 68,769.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 662,646.6 мянган төгрөг буюу 91.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 52,455.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн санхүүжилт 2022 оны 12 сарын 25-ны өдөр төрийн сангийн харилцах дансанд орж ирсний улмаас төлөвлөгөөнд тусгаж зардлын эрхийг нээлгээгүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнээр тооцсон нормативаар	348,873.3	335,070.1	13,803.1	96.9%
2	Үндсэн тусламж үйлчилгээ	175,697.0	151,772.5	23,924.4	94.4%
3	Дээд шатны төсвөөс хуваарилсан	123,220.6	108,492.6	14,727.9	100%
4	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	65,888.6	64,431.2	1,457.3	97.8%
5	Нийтлэг үйлчилгээ	2,880.1	2,880.1	0.0	100%
	Дүн	716,559.9	662,646.6	53,913.2	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Орон нутгийн төсвөөс цалин хөлс, ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэлд 2,880.3 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардал 3,342.6 мянган төгрөг, Түлш халаалтын зардал 59,088.6 мянган төгрөг, цэвэр бохир ус 1,000 мянган төгрөг, урсгал засвар 1,000 мянган төгрөг нийт 67,311.3 мянган төгрөг тус тус зарцуулсан ба гэрэл цахилгааны зардлаас 1,457.6 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтийн дансны авлагын үлдэгдэл 106,547.6 мянган төгрөгийг барагдуулж нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг улсын төсвийн харилцах данс руу бичилт хийж тайлагнасан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2 сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 998,152.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 19,963.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 13,974.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилот, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### 4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг төлөвлөсөн хэмжээнд хянаж үзэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тосонцэнгэл сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд Бизкон аудит ХХК аудит хийсэн ба акт, албан шаардлага өгөөгүй, шилэн данстай холбоотой 1 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эм, багаж тоног төхөөрөмжийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 27,378.5 мянган төгрөгийн эм, 23,852.2 мянган төгрөгийн багаж тоног төхөөрөмж нийт 51,230.7 мянган төгрөгийг тендергүй худалдан авалтаар хийсэн байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 41,215.8 мянган төгрөгийн алдаа<sup>3</sup> илэрснээс аудитын явцад 27,854.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 13,361.8 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналд гарсан дараах алдааг залруулсан. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагыг 15,640.0 мянган төгрөгөөр мөнгөн гүйлгээний орлогын тайланд зөрүүтэй тайлагнасан нь үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Эрүүл энхийн гольдрил ХХК-нд 2022 оны 12 дугаар сарын 23-нд Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 1ш 3,900.0 мянган төгрөг, эмийн хөргүүр 1ш 3,800.0 мянган төгрөг нийт 7,700.0 мянган төгрөг шилжүүлсэн ба хөрөнгө биетээр байхгүй байхад орлого авсныг залруулж авлагаар тайлагнасан.
- Тайлант онд 4,514.0 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн эдийн засгийн ангилал буруу сонгож бүртгэснийг тус тус залруулсан болно.

Аудитаар нийт 13,361.8 мянган төгрөгийн зөрчил<sup>4</sup> илэрснээс, 13,361.8 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

<sup>3</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага тавигдаагүй

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Бараа материал холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Бараа материалыг түүвэрлэн тулгахад нийт 7,062.2 мянган төгрөгийн анхан шатны баримт бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7<sup>5</sup> гэсэн заалттай нийцээгүй ба “Иж бүрэн” байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж тайлагнахгүй байх

#### 2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е – баримт/ баримтгүй 6,299.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн е баримтаар баталгаажуулж анхан шатны баримт бүрдүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Орлогыг мөнгөн гүйлгээний тайланд зөрүүтэй тайлагнасан	1	15,640.0			1	15,640.0	1	15,640.0				
Эдийн засгийн	1	4,514.0			1	4,514.0	1	4,514.0				

<sup>4</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>5</sup> "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно."

Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ангилал буруу сонгосон												
Авлага өглөгийн тооцоо хийж бүртгэх	1	7,700.0			1	7,700.0	1	7,700.0				
Дүн	3	27,854.0			3	27,854.0	3	27,854.0				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны баримт дутуу	1	7,062.2					1	7,062.2				
Е баримтгүй гүйлгээ хийсэн	1	6,299.6					1	6,299.6				
Дүн	2	13,361.8					2	13,361.8				

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЕМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Х.ДИЙМАА ОГНОО:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Л.МАГСАРЖАЛАМ ОГНОО:



*(Handwritten signature)*